


Өвлийн саруудад Монгол орны нутаг дэвсгэр дээгүүр их даралтын орон зонхилон ажиглагддагтай холбоотой цаг агаар гол төлөв тогтуун байдаг. Манай орны 2 дугаар сарын агаарын дундаж температур (1981-2010 оны дунджаар) Алтай, Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутаг, томоохон гол, нуурын сав газраар -24°C (-11.2°F)-аас хүйтэн, говь цөлийн бүс нутгаар -12°C (10.4°F)-аас дулаан, бусад нутгаар -12°C -аас -22°C (10.4°F -аас -7.6°F) байдаг.


Монгол орны хэмжээнд 2 дугаар сард хур тунадас бага унадаг бөгөөд ойролцоогоор жилийн нийлбэр хур тунадасны 1 хувьтай тэнцдэг. Тус сард томоохон гол, нуурын сав газар болон Ховдын урд хэсгээр 3-4.5 мм, Баян-өлгий, Увсын баруун хэсэг, цөлийн бүс нутгаар 0.2-1мм бусад нутгаар 1-2.5мм унадаг байна.



Зураг 1. 1981-2010 оны 2 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны газарзүйн тархалт

2021 оны 2 дугаар сарын агаарын дундаж температур 1981-2010 оны олон жилийн дундаж (ОЖД)-аас 5.0°C -аар дулаан буюу 1940 оноос хойш тохиолдож байгаа 2 дахь дулаан сар болж өнгөрлөө. Бүс нутгаар авч үзвэл (Зураг 2) сарын дундаж агаарын температур ихэнхи нутгаар ОЖД-аас дулаан, ялангуяа нутгийн баруун, хойд, төвийн болон говийн бүс нутгуудаар 5.1 –ээс 11.2°C –аар илүү дулаан байсан байна.


Хур тунадасны хувьд тус сард Монгол орны хэмжээнд дунджаар 1.7 мм тунадас орсон. Бүс нутгаар авч үзэхэд (Зураг 2) нутгийн баруун, зүүн хэсэг болон Хөвсгөл, Баянхонгор, Өвөрхангай, Төв аймгуудын зарим нутгаар ОЖД-аас 60 хувиар бага хур тунадас орсон. Харин нутгийн төв болон зүүн урьд хэсэг, Баян-Өлгийн Булган, Ховдын Булган, Говь-Алтайн Алтайд, Завхан, Хөвсгөл, Дорнод аймгийн зарим нутгаар ОЖД-аас 20-80 хувиар их тунадас оржээ.



Зураг 2. 2021 оны 2 дугаар сарын агаарын дундаж температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлтын газарзүйн тархалт


Монгол орны нийт нутаг болон 4 бүсээр (баруун, төв, өмнө, зүүн) хуваан дунджилсан 2 дугаар сарын хоногийн дундаж агаарын температурын ОЖД-аас хазайх хазайлтын явцыг авч үзэхэд (Зураг 3-а) 1, 3 дугаар арав хоногт нийт нутгаар ОЖД-аас 0.5-аас 16.0°C-аар дулаан, 2 дугаар 10 хоногийн дунд хэсгээр цөөхөн хоногийн хүйтрэлт ажиглагдсан.

Хур тунадасны хоногийн явцыг авч үзэхэд (зураг 3-б) 2-р арав хоногийн эхэнд баруун болон төвийн бүс нутгаар, 3-р арав хоногт зүүн болон өмнө бүс нутгаар харьцангуй ахиу тунадас орсон.



Зураг 3. Хоногийн дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны ОЖД-аас хазайх хазайлт

Тус сард агаарын температурын үнэмлэхүй их утга Өмнөговийн Манлайд 16.6°C, хөрсний температурын үнэмлэхүй их утга Баянхонгорын Эхийнголд 30°C хүрч ажиглагдсан бол үнэмлэхүй бага утга Хөвсгөлийн Ренчинлхүмбэд агаарт -40.5°C, хөрсөнд -43°C хүрч хүйтэрсэн. Хоногт хамгийн их нь Дорнодын Дашбалбарт 21-ний өдөр 6.0 мм тунадас орсон. Даралтын үнэмлэхүй их утга Сэлэнгийн Сүхбаатарт 960.9 гПа, бага утга Баянхонгорын Баянбулагт 761.5 гПа хүрч тус тус ажиглагдсан. Салхины хурд хамгийн их нь Ховдын Зэрэгт 32 м/с хүрчээ.



Зураг 4. Тус сард ажиглагдсан экстремаль утгууд